

**2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 04 дүгээр сарын 07-ны “Баасан” гарагийн өдрийн 12:00 цагаас өмнө e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

Биелэлтийг ирүүлэхдээ үүрэг даалгавар бүрийн хэрэгжилтийн хувийг тодорхой бичиж ирүүлнэ үү.

**Цэвэрлэгээний биелэлтийг ирүүлэхдээ цэвэрлэгээнд хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо, цэвэрлэсэн талбайн хэмжээ болон хог хаягдлын хэмжээг тодорхой бичиж ирүүлэхийг анхаарна уу.**

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
<b>БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>		
1.	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүх шатанд эрчимжүүлж, зураг төсөв, ажлын даалгаваргүй ажлуудыг шуурхай шийдвэрлэж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, захиалагчийн хяналтыг сайтар тавьж ажиллах.	СТСХ, ХААА
<b>ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД</b>		
2.	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт байгаа нийтийн эзэмшлийн талбайн эвдрэл гэмтэл, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, спортын талбайн өнгө, үзэмжийг сэргээх, засварлах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, ААНБ-ууд
3.	Инженерийн шугам сүлжээний засварын ажлын шаардлагаар ухсан зам талбайг нөхөн сэргээхдээ "Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага"-ыг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	ТХҮХ, УСАТ
4.	Нийслэлийн хэмжээнд соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх, соёлын үнэт зүйлсийг өвлүүлэн эзэмшүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хамгаалах болон нийгмийн салбарын ажлуудаа эрчимжүүлж, Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй ажлаа уялдуулан хамтран ажиллах.	НХХ, ААНБ-ууд
5.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр, шинээр бий болсон, байхгүй болсон болон сул чөлөөтэй /байнгын, түр, цагийн/ ажлын байрны талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд, сурталчлах, ажлын байранд зуучлах, ажил, мэргэжлийг чиг баримжаа олгох зөвлөмж, зөвлөгөөг өгөх ажлуудаа эрчимжүүлж, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж нийслэлийн Удирдлагуудад танилцуулах.	ДЗО Б.БОЛОРМАА, ХХҮХ

6.	Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлуудаа эрчимжүүлж, шалтгаан нөхцөлд нь дүн шинжилгээ хийж нийслэлийн Удирдлагуудад танилцуулах	ГБХЗХХ,
7.	Нийслэлийн Татварын газраас орлого бүрдүүлэх ажлын хүрээнд дүүргүүдийн Татварын хэлтсүүдийг нэгдсэн удирдлагаар хангаж, орлого бүрдүүлэх тусгай удирдамж гарган нийслэлийн хэмжээнд орлого бүрдүүлэх ажлаа эрчимжүүлэх.	Татварын хэлтэс
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
8.	Мэдээллийн цаг арга хэмжээг эрчимжүүлэх	ТЗУХ, Соёлын ордон
9.	ААНБ-ууд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, ОУ-ын байгууллагатай харилцаа тогтоох ажлуудаа эрчимжүүлэх	ААНБ-ууд
10.	2023.04.29-ний өдөр зохион байгуулагдах хэт холын марафон гүйлтийн УАШТ-ий бэлтгэлийг хангаж ажиллах	НХХ БТСХ, ААНБ-ууд, Хороод
11.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагууд дотооддоо арга хэмжээ зохион байгуулж ажиллах	ААНБ-ууд
12.	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд орчныхоо 50 м хүртэлх талбайн өнгө үзэмжийг сэргээж, цэвэрлэгээг тогтмолжуулах, хайс хашааг угаах, хогны түүвэр цэвэрлэгээ хийх.	ААНБ-ууд
13.	Өнгөрсөн жил ажил эхэлсэн ч цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан гүйцэтгэл хойшилсон хөрөнгө оруулалтын ажлуудыг (Байрнуудын сандал, ЦХ-ийн хашаа, Фасад) эрчимжүүлж ажиллах	ТХҮХ, ХААА
14.	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой ажлын байрны зар, мэдээлэл солилцох суваг нээж хэрэгжүүлэх	ХХҮХ
15.	Дүүрэгт FM, радио станц байгуулах талаар судлан, хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах	ЗДЗ Г.Дагвадорж, ТЗУХ, ТХҮХ
16.	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж буй тус дүүрэгт оршин суугчаар бүртгүүлээгүй ажилтан, албан хаагчдыг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах	ТЗУХ, ААНБ-ууд
17.	Дүүргийн хэмжээнд гарч буй зөрчлийн тоог бууруулах хүрээнд иргэний бүртгэл, паспорттай холбоотой зөрчлийг арилгуулах талаар тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулж ажиллах	УБХ, Хороод
18.	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлж ажиллах	ХХҮХ